



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар

1/16

Сүмбэр сум

Дотоод хяналт, шалгалтын журам
батлах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод хяналтын багийн ажиллах “Дотоод хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж үнэлэлт дүгнэлт зөвлөмж гаргах эрсдлийн удирдлагаар ханган ажиллахыг Дотоод хяналтын багт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АЛТАНЦЭЦЭГ

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл.

1.1 Монгол улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын заалтуудад нийцүүлэн тус байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалт, дотоод аудитын журам"-ыг батлан хэрэгжүүлнэ.

Хоёр. Дотоод хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, баримтлах зарчим.

2.1 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт аудитын дүнг бодитой, үнэн зөв шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална.

Гурав. Дотоод хяналт шалгалт, дотоод аудитын хамрах хүрээ чиглэл.

3.1 Дотоод хяналт шалгалтын хамрах хүрээ нь:

3.1.1 Байгууллагын дотоод үйл ажиллагаа

3.1.2 Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт

3.1.3 Салбарын эрхлэх асуудлын хүрээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, бодлогын зорилтуудын хэрэгжилтийн үе шат болон дунд хугацааны зорилтод түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ дүгнэлт хийх

3.2. Дотоод хяналт шалгалт нь дараах чиглэлтэй байна:

3.2.1 Салбарын хууль тогтоомж дүрэм журам, стандарт, гэрээ болон эрх бүхий этгээдийн нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт

3.2.2 Санхүү төсвийн үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдал

3.2.3 Төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал.

3.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал.

3.2.5 Санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитын шалгалт төлөвлөсөн хугацаандаа явагдаж байгаа эсэх

3.2.6 Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах

3.2.7 Дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг эргэн хянах, акт төлбөрийн биелэлтэд хяналт тавих

3.2.8 Өөрийн байгууллагын үйл ажиллагаа холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх

3.2.9 Ажлын байрын орчин нөхцөл, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт

Дөрөв. Дотоод хяналт шалгалт, дотоод аудитын удирдлага зохион байгуулалт:

4.1 Албаны даргын тушаалаар байгуулсан дотоод хяналт шалгалтын баг батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллана.

4.2 Дотоод хяналтын багийн дарга нь албаны даргад ажлаа хариуцан тайлагнана.

Тав. Дотоод хяналт шалгалтын багийн эрх, үүрэг:

5.1. Дотоод хяналт шалгалтын баг дараахь эрхтэй:

5.1.1 Холбогдох албан хаагчтай уулзалт ярилцлага хийх

5.1.3 Хяналт шалгалтад хамаарах бичмэл болон цахим баримт, мэдээлэл материалыг гаргуулан авах, хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх

5.1.4 Хяналт шалгалтын үр дүнд өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн, албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлэх

5.1.5 Өмнө хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх

5.1.6 Хууль тогтоомжоор олгосон бусад эрх

5.2. Дотоод хяналт шалгалтын баг дараах үүрэгтэй:

5.2.1 Салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, тогтоомж дүрэм, журам, стандартыг удирдлага болгон ажиллана.

5.2.2 Хяналт шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах

5.2.3 Хяналт шалгалтын явцад танилцсан, олж авсан бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн тухайн шалгалтын үйл ажиллагаанд ашиглах

5.2.4 Дотоод хяналт шалгалтын баг нь аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах

5.2.5 Дотоод хяналтын баг нь үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах

5.2.6 Дотоод хяналт шалгалтыг удирдамжийн дагуу хийх ба удирдамжид заасан зорилго, үндэслэл, хамрах хүрээ, бүрэлдэхүүнээрээ товлосон хугацаанд гүйцэтгэж, байгууллагын удирдлагад тайлагнана.

5.2.7 Удирдамжид заагаагүй үйл ажиллагааг шалгахгүй, бүрэлдэхүүнээс өөр хүн оролцохгүй байх

5.2.8 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг заавал баримтжуулж, баталгаажуулсан байх

5.2.9 Шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар төсвийн шууд захирагчид мэдээлэх

5.2.10 Дотоод хяналтын баг нь мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэх, байгууллагын нийт албан хаагчдыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын талаар тодорхой мэдлэгээр тогтмол хангах

5.2.11 Шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах

5.2.12 Дотоод хяналтын шалгалтын зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх

Зургаа. Дотоод хяналт шалгалтыг төлөвлөх

6.1. Дотоод хяналтын баг нь байгууллагын дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг дараа оны 1 сарын 20-ны дотор гаргаж албаны даргаар батлуулна.

6.2 Тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлд үндэслэн, хамгийн их эрсдэлтэй үйл ажиллагааг хамруулна.

6.3 Тухайн жилийн төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулахдаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ гэсэн үе шатыг баримтална.

6.4 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан болон албаны даргын шийдвэрээр тусгайлан явуулах бусад хяналт шалгалт, холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон хяналт шалгалт бүрт удирдамж гаргаж албаны даргаар баталгаажуулах

6.5 Дотоод хяналтын багийн дарга нь зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана.

6.6 Дотоод хяналтын багийн дарга нь дараахь асуудлаар албаны даргад тайлагнана:

6.6.1 Гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүн, танилцуулгыг тухай бүр албаны даргад танилцуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

6.6.2 Тухайн байгууллагын дотоод хяналтын багийн үйл ажиллагаанд анхаарвал зохих асуудал, саналыг боловсруулан байгууллагын удирдлагыг мэдээллээр хангана.

Долоо. Дотоод хяналт шалгалтад ажлын баримт үйлдэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

7.1 Дотоод хяналтын шалгалтын бичиг баримт нь төлөвлөгөө, удирдамж, танилцуулга, зөвлөмж, дүгнэлт, тайлан байна. Эдгээрийг төрийн албан хэрэг хөтлөх, зохион бүрдүүлэх заавар, стандартын дагуу үйлдэнэ.

7.2 Дотоод хяналт шалгалтын явцад хийсэн бүх үйл ажиллагаанд ажлын баримт бэлтгэн зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн байгууллагын архивт өгнө.

7.3 Шалгалтын үр дүнг оноор, өмнөх шалгалтын дүнтэй харьцуулан тайлагнана.

Найм. Хараат бус байдал.

8.1 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа нь бие даасан хараат бус байдлаар явагдана. Тайлан, шалгалтын дүнг ил тод байршуулна.

8.2 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар албаны даргад мэдээлнэ.

8.3 Дотоод хяналт шалгалтыг хууль эрх зүйн хүрээнд гүйцэтгэхэд албаны дарга бүх талаар дэмлэг үзүүлнэ.

8.4 Холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, үйл ажиллагааны үр дүнтэй, хэмнэлттэй, үр ашигтай байдлыг хангах, дотоод хяналтыг зохистой байдлаар хэрэгжүүлэхэд хүлээх байгууллагын удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх.

Ес. Байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг

9.1 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах үед шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг байгууллагын бүх албан хаагчид хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулга хийхэд оролцох үүрэгтэй.

9.2 Дотоод хяналт шалгалтын багийн гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын бүх албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй.

Арав. Хариуцлага

10.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.